

Н. ИШЖАМЦ

**"АНУ-ААС МОНГОЛЫН ХУВЬД ЯВУУЛСАН БОДЛОГО,
МОНГОЛ- АМЕРИКИЙН ХАРИЛЦАА /1900- 1987/ "**

Өнгөрсөн зууны сүүлчийн арван жилээс Монгол улс олон тулгуурт гадаад бодлого баримтлах болсноор гадаад харилцаа улам бүр өргөжин тэлсээр байгаа билээ. Үүнтэй уялдан манайд олон улсын харилцаа, орон судлалын салбар ч нэлээд эрчимтэй хөгжиж, шинэ сэтгэлгээгээр бичсэн чамбай бүтээлүүд олон арваар гарсаар байна. Үүний нэг нь Монголын түүх, дорно дахин, олон улс судлалын нэрт эрдэмтэн, Монголын АНУ судлалын төвийг үүсгэн байгуулагчдын нэг, түүний анхны тэргүүн, академич **Нямбуугийн Ишжамц агсаны** туурвисан дээрх бүтээл юм. Тэрбээр амьдралынхаа сүүлчийн жилүүдэд Монгол улсад АНУ судлалыг үүсгэн хөгжүүлэх талаар асар их хүчин зүтгэл гаргаж, өөрийн олон талт судалгааны ажлынхаа нэг хэсгийг үүнд зориулсан юм. Монголд АНУ судлалын шан татаж түүний туурвисан энэ чамбай бүтээл гурван бүлэг, өмнөтгөл, дүгнэлт, англи товчлол, ном зүй зэргээс бүрдэл болно. **"Монгол орон-АНУ / XIX зууны дэд хагасаас 1911 он/** хэмээх тэргүүн бүлэгтээ зохиогч Монгол овог угсаатан болон Америкийн Индианчуудын хооронд байж болох түүхэн учир холбогдлыг нэлээд ултай авч үзээд энэ чиглэлээр ултай судалгаа хийх нь чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Түүнчлэн тухайн үеийн олон улсын болон Монгол орны байдал, Америкийн гадаад бодлого зэрэг олон талт асуудлыг эмх цэгцтэй, эрэмбэ дараатай авч үзээд XIX зууны сүүлчээс л АНУ-ын талаас Манж Чин улс, Хятадын зүгт худалдаа, эдийн засаг, дараа нь улс төрийн сонирхол давамгайлж ирсэн. Америк нь бусад хөрөнгөтөн гүрнүүдийн нэгэн адил Хятадын асар уудам багтаамж бүхий зах зээл, байгалийн баялаг, олон тооны хөдөлмөрлөх хямд хүчийг сонирхох тэр л цар хүрээнд XX зууны эхээр Монгол орон түүний анхааралд өртсөн гэж зөв зүйтэй дүгнэсэн байна./7дахь тал/

"Монгол улсыг АНУ сонирхон судлах болсон нь. Хоёр талын анхны оролдлогууд /1911-1945/ гэсэн дэд бүлгийн **"Олноо өргөгдсөний Богд хаант Монгол улсыг анхааран сонирхсон нь. Монголын тавьсан асуудал, хүсэлтүүд"** хэмээх 1-р зүйлдээ Зохиогч Монголын шинэ түүхийн нэн сонирхолтой асуудлын нэг болох Богд хаант Монгол улсын талаар хийсэн олон жилийн судалгааны ажлынхаа дүнг нэгтгэж, Богд хаант Монгол улсыг зөвхөн 1911-1919 онд оршин тогтнож байсан биш, 1921 он хүртэл оршин оршин тогтнож байсан гэсэн маш чухал дүгнэлт хийж өнөө хэр маргаантай байсан асуудлыг нэг мөр болгожээ. Чухамхүү тэр үеийн төр засаг АНУ-тай харилцаа тогтоохыг хүсэж, янз бүрийн арга

хэлбэрээр оролдож байсан болохыг олон сурвалж ашиглан тодорхой өгүүлжээ. Тэр цаг үеийн олон улсын байдлын улмаас АНУ Баруун Европын хөрөнгөтөн орон болон Япон зэрэг тухайн үеийн дэлхийн бодлогыг тодорхойлогч гүрнүүдийн нэгэн адил Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй ч гэсэн Америкийн засгийн газар Монголд чухам юу болж байгаа, Орос, Хятад түүнд хэрхэн хандаж харилцаж байгаа, Монголын дотоод, гадаад бодлого, хөгжлийн цаашдын шинж төлөв зэргийг газар дээр нь очиж нарийвчлан ажиглах, шинжлэх ухааны үндэстэй улс төрийн судалгаа хийж эхэлсэн байна. Тухайлбал, 1913 оны арванхоёрдугаар сард Америкийн томоохон дипломатч, дорнодахинч эрдэмтэн В.В Рокхил, 1916 онд байгалийн ухааны эрдэмтэн Вэбстер, 1919 оноос Нью Йорк дахь Америкийн байгалийн түүхийн музейгээс профессор Р.Ч. Эндрюсээр ахлуулсан шинжилгээний анги ирүүлж ажиллуулсан байна. Төрөл бүрийн мэрэгжлийн эрдэмтэдийн нутагтаа очоод нийтлүүлсэн өгүүлүүд нь Монгол орныг таньж мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж зохиогч үзжээ /14-16 дахь тал/.

Академич Н. Ишжамц АНУ-ын засгийн газар Манжуур, Монголд Японы түрэмгийлэл идэвхжиж, тэнд түүний ноёрхол тогтохоос болгоомжлон Оросын зүгээс Алс Дорнод, Сибирь нутгаа аливаа аюул довтолгооноос урьдчилан сэргийлэхийн тул Монголоор завсарын бамбай бүс болгох гэж байна хэмээн үзэж, түүнд харилцан ойлголцох байдлаар хандаж байсан гэсэн Америкийн эрдэмтдийн дүгнэлттэй санал нэг байгаагаа илэрхийлсэн байна/ 16 дахь тал/. Түүнчлэн Богд хаант Монгол улсын засгийн газраас Америктай дипломат харилцаа тогтоох асуудлыг нэн шаргуу тавьж байсан боловч Хятадын эсэргүүцэл, бусад улс гүрний дургүйцэх байдлын улмаас зүрхлэн зөвшөөрсөнгүй. Гэсэн ч 1920 оны дөрөвдүгээр сарын сүүлч, тавдугаар сарын эхээр Америкийн засгийн газар Өвөр Монгол, Хятадын нутгийн зааг дээрхи Хаалган хотод өөрийн Консулын газрыг нээсэн байна. Энэ нь нэг талаар Өвөр Монголыг ажиглах гэхээсээ илүүгээр Ар Монгол, тэндэх Орос, Японы зөрчлийг судлахад бас багагүй анхаарч байсны үр дүн, нөгөө талаар монголчууд түүгээр дамжуулан Америктай харилцах шинэ суваг нээгдэхэд хүргэсэн хэмээн дүгнэсэн байна. Зохиогч цааш нь "Уг нь АНУ, Орос, Япон, барууны зарим улс гүрний адил нөлөөний хүрээний холбогдолтой янз бүрийн гэрээ хэлэлцээрт хутгалдан орж чөлөрлөгдөн ногтлогдоогүй байсан учир нэлээд чөлөөтэй хөдөлж болох байсан. Гэсэн ч Монголын талаархи Хятадын байр суурь, бусад улс орнуудын нөлөөний хүрээний тухай хэлцэл тохиролцоо, түүнчлэн өөрийн зүгээс Монголын хэт алслагдсан байдал, зах зээлийнх нь өчүүхэн багтаамж зэргийн учир асар их хүчлэн сонирхох үндэсгүй байсны улмаас Монголын асуудалд

ихээхэн болгоомжтой хандаж байжээ. Тийм учраас Монголын удаа дараагийн санал хүсэлтийг хүлээн авч, сайн мэдэж байсан боловч ямарч албан ёсны хариу өгөлгүй, бараг зөвхөн алсын бодолтой, өвөрмөц нөөц идэвхжил бүхий байнгын ажиглагчийн байдалтай үлдэж байсан. Тэгэхдээ АНУ нь Монгол орон, түүний холбогдолтой асуудлыг хараанаасаа хэзээ ч гарган зөнд нь хаяж байсангүй, улам улмаар нарийвчлан судалж, олон улсын байдал өөрчлөгдсөн цагт өөрийн нөлөөг Монголд зохих хэмжээгээр нэвтрүүлэх ирээдүйн төлөвийн асуудлыг мартсангүй, харин түүний боломж ба ашгийн талыг тооцон харсаар байсан” гэсэн ул үндэстэй, сонирхолтой, дүгнэлт хийжээ / 18 дахь тал/.

“Ардын хувьсгалт Монгол Улсыг Америк судалж, мэдэх болсон нь. Албан ба албан бус хандлага, харилцаа” гэсэн хоёрдугаар зүйлдээ зохиогч 1921- ээс дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд Монгол улсын засгийн газраас Орос, Хятадаас гадна АНУ зэрэг бусад улс оронтой харилцаа байгуулж, тэднээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийг ихэд анхааран олон талт арга хэмжээ авч байсныг хураангуйлан дүгнэсэн байна. Ялангуяа АНУ-аар тусгаар тогтнолоо хүлээлгэн зөвшөөрүүлж, ЭСЯ нь солилцох явдал Монголын засгийн газрын анхаарлыг татаж, Хаалган дахь АНУ-ын консулын газраар дамжуулан Америктай холбоо барьж, албан ёсны харилцаа байгуулах оролдлого хийж байсныг баримтаар тодорхой өгүүлжээ.

АНУ-ын Засгийн газар ч гэсэн хэдийгээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх бодолгүй байсан боловч Зөвлөлт Оросын дэмжлэгтэй ардын засаг Монголд байгуулагдаж, Оросын улаан цэрэг тэнд байрлаж байгаа явдал, түүнчлэн тийм нөхцөлд Монголтой худалдаа арилжаа хийх, хөрөнгө оруулахад ямар болох, түүнтэй уялдуулан Монголын талаас Хятад Зөвлөлт болон Алс Дорнодын Бүгд Найрамдах улстай хэрхэн яаж харилцаж байгаа, тэдний хооронд чухам юу болж байгаа зэргийг сонирхож, Хаалган дахь консулын газраараа дамжуулан Монгол ард улстай арга буюу албан ёсны ба албан бус шугамаар нилээд хэмжээгээр харилцах болсныг Америкийн монголч эрдэмтэн Алисиа Ж.Кампийн судалгааны бүтээлээс иш татан дэлгэрэнгүй өгүүлжээ.

Академич Н.Ишжамц Монгол улсыг хөрөнгөтөн орнуудаас хөндий тасархай байлгах гэсэн Зөвлөлтийн бодлого, хөрөнгөтөн гүрнүүдийн зүгээс Монгол улсыг хүлээн зөвшөөрөхгүй явсаар ирсэн зэрэг нь дэлхийн хоёрдугаар дайны нөхцөл дэхь олон улсын хоорондын байдал нягт холбоотой байсан болохыг ул үндэстэй авч үзсэн байна. Энэ үеийн Америкийн засгийн газар бусад олонхи хөрөнгөтөн орнуудын нэгэн адилаар Монгол улсыг Хятадын хэсэг

атлаа Зөвлөлтийн нөлөөнд хүчтэй автагдан түүний нэг мужийн хэмжээнд ойлгож Монгол улстай ямар нэг харилцаа байгуулахыг чухалчилдаггүй байсан гэсэн дүгнэлт хийжээ. /32 дахь тал/

“АНУ БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн нь Монгол улс НҮБ-д элссэн ба Монгол Америкийн хооронд дипломат харилцаа байгуулагдсан нь /1945-1987/” гэсэн 3 дугаар бүлгийн **“БНМАУ-ыг Америк хүлээн зөвшөөрсөн нь”** хэмээх нэгдүгээр зүйлдээ өгүүлэн буй үеийн Монголын дотоод гадаад байдал, Монгол Зөвлөлтийн харилцаа олон улсын дундах Монгол улсын байр суурийн асуудлаар АНУ зэрэг гадаадын улс орон, эрдэмтэн мэргэжилтэн нар өөр хоорондоо адилгүй зарим зүйл дээр эрс зөрөөтэй санаа, дүгнэлт гаргаж байсан боловч ерөнхийдөө сөрөг тал нь саарч, эерэг тал нь нэмэгдэх хандлагатай болж, Америкийн удирдлагын зарим эрх баригчид Монгол улсыг биеэ даасан төр улсынх нь хувьд биш зөвхөн нэг газар нутаг, Хятад Зөвлөлтийн хоорондох дэвсгэр нутаг төдий үзэж бас зэргэлдээх улс орнуудад Зөвлөлтийн нөлөөг өргөжүүлэх түшиц газар болох мэтээр хардаж, сэрдэн хандаж байсан явдал нь цаашдын хүйтэн дайны нөхцөлд Монгол улсыг НҮБ-д элсүүлэхээс татгалзаж байсаны нэг гол шалтгаан байж бүрэн болно гэж дүгнэн бичсэн байна /42 дахь тал/

“Монголын хувьд НҮБ-ийн шугамаар Америкийн явуулсан жич бодлого, БНМАУ НҮБ-д элссэн нь” гэсэн хоёрдугаар зүйлдээ Монгол улсын талаар НҮБ-ийн шугамаар АНУ-ын явуулж ирсэн бодлогыг эрэмбэ дараатай системчлэн авч үзээд 1961 оны 10 дугаар сарын 27-нд НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн XXVI чуулганаар БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсүүлэн баталсан явдал Монгол улсын тусгаар тогтнол, олон улсын дундах байр суурийг улам бэхжүүлэхэд том алхам болсон гэж дүгнэсэн байна./51 дэх тал/

“Монгол улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа байгуулагдсан нь, түүний ач холбогдол” гэсэн 3 дугаар зүйлдээ зохиогч олон улсын харилцааны шинэ нөхцөлд өөрчлөлт шинэчлэлийн бодлогод шилжсэн ЗХУКН Зөвлөлтийн засгийн газар ч Монгол Америкийн хооронд дипломат харилцаа байгуулагдахыг зохисгүй цаг үе нь тохиромжгүй юмуу, ерөөс хараахан болоогүй байна хэмээн үзэхээ больж, аливаа хориг саад хийхгүй болж ирсэн байна. 1986 оны 7 дугаар сард НҮБ-д сууж байсан АНУ-ын байнгын төлөөлөгч хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар хэлэлцээ хийхийг албан ёсоор санал болгосны үндсэн дээр мөн оны сүүлчээр уг хэлэлцээр эхэлжээ. Энэ удаагийн хэлэлцээр ихээхэн шуурхай бөгөөд амжилттай болж 1987 оны 1 дүгээр сарын 27 -ны өдөр БНМАУ, АНУ-ын хооронд Элчин сайдын түвшинд дипломат харилцаа

байгуулагдсан билээ. Энэхүү түүхэн үйл явцыг зохиогч “Монгол улс дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй хүчирхэг хэт их гүрэн АНУ-ын хооронд Дипломат харилцаа байгуулагдсан явдал манай улсын бүрэн эрхт байдал, олон улсын дундах байр суурийг үлэмжхэн бэхжүүлж, түүний улс төр техник эдийн засаг шинжлэх ухаан соёлын цаашдын хөгжил, нийгмийн амьдралд ихээхэн тус нэмэр болох түүхэн чухал ач холбогдолтой /60 дахь тал/ гэж зөв зүйтэй дүгнэсэн байна.

Монголын нэрт эрдэмтэн, академич Н.Ишжамц агсны туурвисан энэхүү бүтээл нь Монгол улсын улс төрийн гадаад харилцааны ажилтан, судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын гарын авлага болохуйц чамбай бүтээл болсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭРДЭМТДИЙН ХАМТЫН БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Монгол-Хятадын харилцаа өнгөрсөн зууны 90-ээд оноос улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан зэрэг нийгмийн амьдралын бүх салбарыг хамран эрчимтэй өргөн хөгжиж байна. Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаа ч урьд өмнө байгаагүйгээр өрнөн хөгжиж байна. Урьд өмнө хоёр орны эрдэмтэд хамтран эрдмийн бүтээл туурвих асуудал төдий л түгээмэл байсангүй. Сүүлийн хэдэн жилд шинжлэх ухааны бараг бүх салбарт хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, эрдэмтэд харилцан солилцох, туршлага судлах, олон улсын хурал хамтран зохион байгуулах, сорилт туршилт хийх, хамтын бүтээл туурвих зэргээр үр бүтээлтэй, өгөөжтэй ажиллаж байна. Үүний нэг тодорхой жишээ нь: **“Монгол-Хятадын харилцаа: Нийгэм-эдийн засгийн зарим асуудал (XX зууны 90-ээд он)”** УБ.2001 он /хамтын бүтээл юм. Доктор Ph.Л.Бэгзжавын орчуулж, эмхэтгэсэн энэхүү хамтын бүтээл нь хоёр улсын эрдэмтдийн олон жилийн нягт хамтын ажиллагааны үр дүнд бий болсон гэж үзэх үндэстэй.

1998 онд манай хүрээлэн Зүүн хойт Азийн асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан билээ. Энэ хуралд ӨМӨЗО-ы Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн эрдэмтэд оролцож сонирхолтой хэд хэдэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Энэхүү номын үндсэн хэсэг нь дээрх илтгэлүүдээс сонгон авч оруулснаас гадна БНХАУ-ын Зилинь мужийн Зүүн Хойт Ази судлалын төвийн эрдэмтэд, монгол улсын эрдэмтдээс ЗХА, Монгол-Хятадын харилцаа, ӨМӨЗО-ы нийгэм-эдийн засгийн өргөн хүрээтэй асуудлаар бичсэн судалгааны өгүүлүүдээс бүрдэл болно.